

ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
АНХАН ШАТНЫ БҮРТГЭЛД АНГИЛАЛ,
КОД АШИГЛАХ ЗААВАР

Улаанбаатар хот
2014 он

ГАРЧИГ

1. Удиртгал..... 3
2. Сангийн Сайд, Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Сайдын 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 24/А/20 тоот хамтарсан тушаал 4
3. Үндэсний Статистикийн Хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 1/158 тоот тушаал 5
4. "....."-ний нийгмийн даатгалын шимтгэллөлтийн ... оны ... -р сарын тайлан – МАЯГТ НД-7, нөхөх заавар..... 6-11
5. ".....".....-д ажиллаж буй даатгуулагчийн оны-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт - МАЯГТ НД-8, нөхөх заавар..... 12-15
6. Үндэсний Ажил Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт -08-ыг ашиглах заавар..... 16-38
7. Эдийн Засгийн Бүх Төрлийн Үйл Ажиллагааны Салбарын Ангилал - 4.0 ба тодорхойлолтыг ашиглах заавар..... 39-55
8. Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгжийн код..... 56-60

УДИРТГАЛ

Төрийн мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ бий болгох, түүний ашиглалтыг сайжруулах, мэдээллийн давхардлыг арилгах, мэдээлэгчид очиж буй дарамтыг бууруулах, мөн Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал Тодорхойлолт-08 (YAMAT-08), Эдийн Засгийн Бүх Төрлийн Үйл Ажиллагааны Салбарын Ангилал- 4.0 (ЭЗБҮАСА-4.0), Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн нэгжийн код (МУЗЗНДНК)- ыг ашиглах зэрэг хэрэгцээ, шаардлагын дагуу нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлд мөрдөж байгаа:

~ "....."-ний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийноны-р сарын тайлан - **Маягт НД-7**,

~ "....."-д ажиллаж буй даатгуулагчийн оны-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт- **Маягт НД-8** -г

шинэчлэн боловсруулж, Үндэсний Статистикийн Хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 158 тоот тушаалаар зөвшөөрснөөр, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 24/А/20 тоот хамтарсан тушаалаар баталсан юм.

Шинэчлэн батлагдсан НД-7 маяганд Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгжийн код, Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал-4.0, Байгууллагын хариуцлагын хэлбэр болон өмчийн хэлбэрийг, НД-8 маяганд Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт-08-г ашиглахаар оруулсан бөгөөд мэдээлэгч байгуулагуудад эдгээр ангилал, кодын талаар нэгдсэн ойлголтыг өгөх, оновчтой ашиглахад нь хувь нэмэр болох, ялангуяа цаасаар мэдээлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал, кодыг нөхөхөд зориулж уг гарын авлагыг бэлтгэсэн юм.

Энэхүү гарын авлагад шинэчлэн батлагдсан маягт болон ашиглаж байгаа ангилал, кодыг оруулсан бөгөөд Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал Тодорхойлолт-08 (YAMAT-08)- г хураангуй хэлбэрээр оруулсан тул YAMAT-08-ын дагуу ажиллагчдыг кодлоход хүндрэлтэй тохиолдол гарвал аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс болон статистикийн хэлтэст хандах мөн Үндэсний Статистикийн Хорооны 265543 дугаарын утсаар холбогдож болно. YAMAT-08-г дэлгэрэнгүй байдлаар www.ndaatgal.mn вэб сайт дээр байршуулсан учир татаж ашиглах боломжтой юм.

Харин цахим хэлбэрээр мэдээлж буй аж ахуйн нэгж, байгууллага www.ndaatgal.mn вэб сайт дээр байршуулсан гарын авлага, зөвлөмжийг татаж, ашиглах боломжтой.

Аж ахуйн нэгж, байгууллага мэдээллээ үнэн зөв, бодитой мэдээлэх нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг ялангуяа нийгмийн хамгааллын салбарын тоо, мэдээлэл, мөн хүн амын хөдөлмөр эрхэлт, цалин хөлс, хүний нөөцийн талаарх тоо, мэдээллийг боловсруулан шинжлэх, дүгнэлт гаргах, бодлого, төлөвлөлтөнд ашиглах чухал ач холбогдолтой юм.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ХОРОО

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ

ГАЗАР

**САНГИЙН САЙД, ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2014 оны 22 дугаар
сарын 10-ны өдөр

№ 24 / А/20

Улаанбаатар
хот

Маягт, нөхөх зааврыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нийгмийн даатгалын тухай хуулийн 14.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Үндэсний Статистикийн Хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/158 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18/03 тоот хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралтын “.....-ний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийноны.....-р сарын тайлан” /Маягт НД-7/, “-д ажиллаж буй даатгуулагчийноны.....-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт” /Маягт НД-8/-ын маягт, нөхөх зааврыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэ тушаалаар баталсан маягтууд болон Үндэсний Статистикийн Хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/158 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу холбогдох мэдээллийг гарган жил бүрийн 2, 5, 8, 11 дүгээр сарын 28-ны өдрийн дотор Үндэсний статистикийн Хороонд хүргүүлж байхыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шижилгээ, дотоод аудитын газар /Д.Эрдэнэсүвд/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээлэл технологийн төв /Г.Хүрэлбаатар/-д тус тус даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Отгонжаргал/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Уртнасан/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18/03 тоот хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралтын “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийноны.....сарын.....өдрийн тайлангийн маягт /НД №07/ , “.....-д ажиллаж буй даатгуулагчийноны.....сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн хуудас /НД№08/ маягтуудыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.





МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 1/458

Улаанбаатар хот

Маягт, нөхөх зааврыг батлах,
зөвшөөрөх тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Үндэсний Статистикийн Хорооны даргын зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цалин хөлсний статистикийн мэдээллийн дор дурдсан маягт, нөхөх зааврыг 1 дүгээр хавсралтаар баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын оны -р улирлын мэдээ (Маягт ЦС-1, ЦС-1А, ЦС-1Б, ЦС-2)
2. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингийн оны -р улирлын мэдээ (Маягт ЦС-3, ЦС-3А, ЦС-3Б);

Хоёр. Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн дор дурьдсан мэдээллийн маягт, нөхөх зааврыг баталж, 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /Төрийн нарийн бичгийн дарга Б. Отгонжаргал/-нд зөвшөөрсүгэй. Үүнд:


1.-ний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн оны -р сарын тайлан (Маягт НД-7);
2.- д ажиллаж буй даатгуулагчийн оны-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт (Маягт НД-8)
- 3.

Гурав. Энэ тушаалаар батлагдсан маягтын үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллийг гарган 2, 5, 8, 11-р сарын 28-ны дотор ҮСХ-нд ирүүлж байхыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Эрдэнэсүвд/-т, цалин хөлсний статистикийн үзүүлэлтүүдийг улсын хэмжээнд нэгтгэн мэдээлж байхыг Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газар /Д.Оюунчимэг/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Т.Гантөмөр/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргаа, удирдлагын газар /Г.Нарангэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

Тав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үндэсний Статистикийн Хорооны даргын 2012 оны 1/146 дугаар тушаалыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Байгууллагын нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу мэдээллийн нууцыг чандлан хадгална.

.....-НИЙ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН
 ОНЫ -Р САРЫН ТАЙЛАН

1. Ажил олгогч нь **А хэсгийн** мэдээллийг жил бүрийн 2-р сарын 5-ны дотор онлайн программд шивэх ба маягтаар баталгаажуулан жил бүрийн 2-р сарын 20-ны дотор харьяа аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

2. Ажил олгогч нь **Б хэсгийн** мэдээллийг сар бүрийн 5-ны дотор онлайн программд шивэх ба цаасаар баталгаажуулж сар бүрийн 5-ны дотор харьяа аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

А. АЖИЛ ОЛГОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

А.1 Нэрийн хэсэг

	Нэр				Код			
Ажил олгогчийн нэр								
Байгууллагын регистрийн дугаар								
Үйл ажиллагааны чиглэл								

А.2 Хаягийн хэсэг

Байршил	Нэр				Код			
Аймаг, нийслэлийн нэр, код								
Сум, дүүргийн нэр, код								
Баг, хорооны нэр, код								
Гудамж, хороолол								
Байшин, байр								
Хашаа, хаалганы дугаар								

Суурин утас		
Гар утас	Захирал	
	Ня-бо	
.....		
Факс		
Цахим шуудан		
Цахим хуудас		

А.3 Хариуцлагын хэлбэр /тохирохыг дугуйлна уу/

Нэр	Код
Хувьцаат компани	10
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	20
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	21
Хоршоо	30
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	41
Төсөвт байгууллага	60
Үүнээс: Цэрэг цагдаагийн	61
Төрийн бус байгууллага	70
Бусад	80

А.4 Өмчийн хэлбэр /тохирохыг дугуйлна/

	Нэр	Хувь	Код
Төрийн	өмчийн		11
	өмчийн оролцоотой		12
	хамтарсан%	13
Орон нутгийн	өмчийн		30
	өмчийн оролцоотой		31
	хамтарсан%	32
Хувийн	Монгол Улсын		21
	гадаадтай хамтарсан%	22
	гадаад улсын		23

А.5 Харилцах дансны мэдээлэл

№	Банкны нэр	Дансны дугаар							
1									
2									
3									
4									
5									

Б. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТ

Ажил олгогчийн нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--

1. Шимтгэл төлөлт

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Мөрийн дугаар	Шимтгэл төлөлт					
		Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдагчид	Зөвхөн эрүүл мэндийн даатгалд хамрагдагчид	Хүүхдээ асарч буй чөлөөтэй эх, дайчлагдагчид, гэрээгээр суралцагчид, цэргийн албан хаагчид	Тэтгэвэр тогтоолгосон ажиллагчид	Бусад	Бүгд
А	Б	1	2	3	4	5	6=(1:5)
Даатгуулагчдын тоо	Монгол	1					
	Гадаад	2					
Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого	Үндсэн ба нэмэгдэл цалин	3					
	Шагналт цалин	4					
	Бусад нэмэгдэл цалин	5					
	Хоол, унааны хөлс	6					
	Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт	7					
	Дүн 8=(3+4+5+6+7)	8					
Шимтгэл ногдуулах хувь		9					
Нийгмийн даатгалын санд	Төлбөл зохих НДШ-ийн дүн	10					
	Төлсөн НДШ-ийн дүн	11	x	x	x	x	x
Нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон шимтгэлийн дүн		12	x	x	x	x	x

2. Шимтгэлийн үлдэгдэл

№	Үзүүлэлт	Илүү	Дутуу
1 оны сарын 1-ний үлдэгдэл		
2 оны сарын -ний үлдэгдэл		

3. Тухайн сард дансанд шилжүүлсэн шимтгэл

№	Он	сар	өдөр	Дүн
1				
2				
3				
4				
5				
Нийт дүн				

Тайлан гаргасан:

Тамга, Дарга/захирал: /...../
тэмдэг (гарын үсэг) (нэр)

Нягтлан бодогч: /...../
(гарын үсэг) (нэр)

Огноо:

Шалгаж, хүлээн авсан:

Тэмдэг Нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/: /...../
(гарын үсэг) (нэр)

Огноо:

Энэхүү тайлан нь ажил олгогч болон нийгмийн даатгалын байгууллага хоорондын шимтгэл ногдуулалт, төлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн тооцооны үндсэн баримт болно.

Ажил олгогч нь ".....".....- д ажиллаж буй даатгуулагчийн оны-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт буюу маягт НД-8- ыг үндэслэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн оны -р сарын тайлангийн маягт НД-7-гийн мэдээллийг гаргана.

Уг маягт нь А (Ажил олгогчийн мэдээлэл), Б (Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт) гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Ажил олгогч нь **А хэсгийн** мэдээллийг жил бүрийн 2-р сарын 5-ны дотор онлайн программд шивж, цаасан хэлбэрээр баталгаажуулж жил бүрийн 2-р сарын 20-ны дотор харьяа аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ. **Б хэсгийн** мэдээллийг сар бүр гаргах бөгөөд дараа сарын 5-ны дотор онлайн программд шивж, цаасаар баталгаажуулж дараа сарын энэ хугацаанд багтаан харьяа аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын хэлтэст ирүүлнэ.

А. АЖИЛ ОЛГОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

А.1 Нэрийн хэсэг

- **Ажил олгогчийн нэрийг** тодорхой бичнэ.
- **Регистрийн дугаарыг** тухайн ажил олгогчийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэж бичих ба 7 оронтой тоо байна. Харин ажил олгогч нь хувь, иргэн байвал тухайн ажил олгогч хувь хүний регистрийн дугаарыг бичнэ.
- **Үйл ажиллагааны чиглэлийн нэр, код:** Ажил олгогчийн үйл ажиллагааны чиглэлийн нэр, кодыг нөхөж бичихдээ эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал - 4.0 хувилбарын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй, бичиж, тохирох кодыг нөхнө. Жишээ нь: Гоо сайхны бүтээгдэхүүний бөөний худалдаа, Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа гэх мэт. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал- 4.0-г дэлгэрэнгүй байдлаар энэ гарын авлагын 39-55 -р хуудаснаас харна уу.

А. 2 Хаягийн хэсэг

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичиж, тус тус тохирох кодыг уг гарын авлагын 56-60-р хуудсанд буй Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодоос харж нөхнө.
- Гудамж, хорооллын нэрийг бичиж, кодыг нөхнө.
- Байшин, байр, хашаа, хаалганы дугаарыг нөхөж бичнэ.

А. 3 Аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр

Ажил олгогчийн хариуцлагын хэлбэрийг хүснэгтээр өгөгдсөн ангиллын дагуу тодорхойлно. Хариуцлагын хэлбэрийн 10, 11, 20, 21, 30, 40, 41, 60, 61, 70 ангиллуудад хамаарахгүй аж ахуйн нэгж, байгууллагыг “бусад” буюу 80 гэсэн ангиллаар бүртгэнэ. Тухайлбал, хувийн сургууль, эмнэлэг, дуу бүжгийн хамтлаг гэх мэт улсын бүртгэлийн албанаас гэрчилгээ аваагүй, БШУЯ, ЭМЯ зэрэг байгууллагаас зөвшөөрөл авсан нэгжийг 80 кодоор кодолно.

Цэрэг цагдаагийн буюу 61 гэсэн хэлбэрт зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа явуулж буй байгууллага хамаарна.

Төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ. Шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудыг төрийн бус байгууллага буюу 70 гэсэн кодоор кодолно.

Хариуцлагын хэлбэр /тохирохыг дугуйлна/

Нэр	Код
Хувьцаат компани	10
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	20
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	21
Хоршоо	30
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	41
Төсөвт байгууллага	60
Үүнээс: Цэрэг цагдаагийн	61
Төрийн бус байгууллага	70
Бусад	80

А. 4 Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэр

Ажил олгогчийн өмчийн хэлбэрийг хүснэгтээр өгөгдсөн ангиллаас тохирох кодыг дугуйлна.

Өмчийн хэлбэр нь хамтарсан аж ахуйн нэгжийн хувьд гадаад болон дотоодтой хамтарсан өмчийн эзлэх хувийг нөхөх бөгөөд хэрэв өмчийн хэлбэр нь төрийн хамтарсан бол төрийн өмчийн эзлэх хувийг, орон нутгийн хамтарсан бол орон нутгийн өмчийн эзлэх хувийг, хувийн гадаадтай хамтарсан бол гадаадын өмчийн эзлэх хувийг тус тус нөхнө.

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг **төрийн өмчит хуулийн этгээд** гэнэ. */"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол улсын хуулийн 13 дугаар зүйлд зааснаар/*

Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг **төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд** гэнэ. */"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол улсын хуулийн 21 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар/*

Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж **хамтарсан үйлдвэр** байгуулна. */"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол улсын хуулийн 57 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар/*

Өмчийн хэлбэр

Нэр		Хувь	Код
Төрийн	өмчийн		11
	өмчийн оролцоотой		12
	хамтарсан%	13
Орон нутгийн	өмчийн		30
	өмчийн оролцоотой		31
	хамтарсан%	32
Хувийн	Монгол Улсын		21
	гадаадтай хамтарсан%	22
	гадаад улсын		23

А. 5 Харилцах дансны мэдээлэл

Ажил олгогчийн харилцдаг банкны нэр, дансны дугаарыг нүдэнд бичнэ.

Б. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТ

Ажил олгогчийн нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар нь 9 оронтой тоо байна.

1. Шимтгэл төлөлт

Уг тайлан нь даатгуулагчдын тоо, тэдгээрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл ногдуулах хувь, төлбөл зохих НДШ-ийн дүн, төлсөн НДШ-ийн дүн, нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон шимтгэлийн дүн гэсэн үзүүлэлтийг хуульд заасан төрлөөр тус тусад нь тооцож харуулна.

Шимтгэл ногдуулах хувь буюу 9-р мөрөнд даатгуулагчийн төрлөөсөө хамаарч өөр өөр хувь бичигдэх бөгөөд даатгуулагчийн төрлийн кодоос харж хувийг бичнэ.

9-р мөрний 1-р баганад аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байгаа заавал даатгуулагчид хамрагдах бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлөх хувийг ажил олгогчийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч 21-23 хувийг,

9-р мөрний 2-р баганад зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, комиссар, офицер, ахлагч, түрүүч(цаашид цэргийн албан хаагч)-д хамрагдах бөгөөд зөвхөн эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл төлдөг 4 хувийг,

9-р мөрний 3-р баганад Засгийн газраас баталсан тухайн үеийн мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлдөг ажил олгогчийн захиалгаар суралцагч, хүүхдээ асарч буй эх, ажиллаагүй үедээ дайчлагдсан даатгуулагч, хууль бусаар ажлаас зайлуулагдан, мөрдөгдөн, хилс хэргээр хоригдсон даатгуулагч хамрагдах бөгөөд 7.8 хувийг,

9-р мөрний 4-р баганад тэтгэвэр авагчийг ажиллуулж байгаа ажил олгогч нь эрүүл мэнд болон ажилгүйдлийн шимтгэлээс бусад санд төлөх, үйл ажиллагааны чиглэлээс хамаарч 16.-18.6 хувийг тус тус сонгож шимтгэл ногдуулах хувийг тодорхойлно.

Бусад буюу 5-р баганад 1-4-р баганад ороогүй даатгуулагчдын мэдээллийг бичнэ. Тухайлбал: Хилийн цэргийн дугаар ангид жирэмсэний тэтгэмж авсан эх, Улсын хил дээр алба хааж буй, ахлагчийн гэр бүлийн шимтгэл төлөх тохиолдолд:

Эхийн тэтгэмжийн шимтгэл ногдуулах 11 хувь, алба хааж буй ахлагчийн гэр бүлийн шимтгэл ногдуулах 9 хувийг сонгох бөгөөд арифметик дунджаар шимтгэл ногдуулах хувийг тодорхойлно. $(11+9)/2=10$ хувь

Төлвөл зохих НДШ-ийн дүн буюу 10-р мөр нь 8-р мөрийг 9-р мөрөөр үржүүлсэнтэй тэнцүү байна. 10 мөрийн 6-р баганы дүн НД-8 маягтын 7-р баганын бүгд дүнтэй тэнцэнэ.

11-р мөрний зөвхөн 6-р багана нөхөгдөх бөгөөд тухайн ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийн дүнг бичнэ. Уг дүн нь тухайн сард дансанд шилжүүлсэн шимтгэлийн бүгд дүнтэй тэнцэнэ.

12-р мөрний 6-р баганад нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон шимтгэлийн дүнг бичнэ.

2. Шимтгэлийн үлдэгдэл

Ажил олгогч нь тайлант хугацаанаас өмнөх үеийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг “илүү” буюу 1-р мөр, өглөгийг “дутуу” буюу 2 -р мөрөнд дүнгээр бичнэ.

3. Дансанд шилжүүлсэн шимтгэл

Нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийг огнооны дарааллаар бичиж тэмдэглэнэ.

Төлсөн шимтгэлийн нийлбэр дүн нь **1. шимтгэл төлөлт** хүснэгтийн 11-р мөрний 6-р баганын тоотой тэнцүү байна.

Ажил олгогчийн дарга /захирал/, нягтлан бодогч нь нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн сарын тайланд гарын үсэг зурж тамга /тэмдэг/ дарсан байх бөгөөд уг тайланг нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/ шалгаж, хүлээн авч баталгаажуулна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар залт, Байгууллагын нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн
2 дугаар заалтын догуу мэдээллийг нууцлалын чандалд хадгалав.

.....ДАЖИЛГАЖ БҮЙ ДАТГУУЛАГЧИЙН ОНЫ-Р САРЫН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ НОГУУЛАЛТ

1.Ажил олгогч нь 1-9-р баганын мэдээллийг сар бүрийн 5-ны дотор онлайн программд шиеж, цаасар багалаажуулж
сарьяа аймаг, дүүргэгсүм-ийн нийгэмийн даатгалын байгууллагад оруулна,
2.Ажил олгогч нь 10-р баганын мэдээллийг сар бүрийн 5-ны дотор онлайн программд шиеж,
цаасар багалаажуулж сарьяа аймаг, дүүргэгсүм-ийн нийгэмийн даатгалын байгууллагад оруулна.

**Ажил олгогчийн нийгмийн
даатгалын сургээлийн дугаар:**

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

3.Ажил олгогч нь "тодруулсан 11, 12-р баганын мэдээллийг жил бүрийн 5-р сарын 5-ны дотор, хэрэв өөрчлөлт орсон
тохиолдолд улирлын дараа сарын 5-ны дотор онлайн программд шиеж ба цаасар багалаажуулж аймаг, дүүргэгсүм-ийн
нийгэмийн даатгалын байгууллагад оруулна.

Тусгаар Эцэг/эхийн нэр	Нэр	Даатгалын нийгэмийн даатгалын дугаар		Нийгмийн даатгалын дагварийн дугаар	Даатгалын гэрэлт гэрэл	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /гөрөөл/	Нөдүүлсэн шимтгэл /гөрөөл/		Даатгуулагчийн		И-нэйл хагт	
		Регистрийн дугаар	Нийгмийн даатгалын дугаар				Нийт дүн	Үүнээс:	Ажил олгогч	Даатгуулагч		Ажил мөргэжлийн ангилал
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	1											
	2											
	3											
	4											
	5											
	6											
	7											
	8											
	9											
	10											
	11											
	12											
	13											
	14											
	15											
Дүн												

Төрийн тусламжтайгаар "МОНГОЛ УЛСЫН САЙБАН"
Тамга тэмдэг: / (нэр)
Төрийн тусламжтайгаар "МОНГОЛ УЛСЫН САЙБАН"
Тэмдэг: / (сарын үсэг)
Нягтлан бодогч: / (нэр)
Төрийн тусламжтайгаар "МОНГОЛ УЛСЫН САЙБАН"
Нягтлан бодогч: / (сарын үсэг)
Төрийн тусламжтайгаар "МОНГОЛ УЛСЫН САЙБАН"
Нягтлан бодогч: / (нэр)

Энэхүү тооцооны хуудас нь тухайн ажил олгогчдод ажиллаж буй даатгуулагч бүрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, түүнд ногдуулсан шимтгэлийн талаарх мэдээллийг харуулна.

Ажил олгогч нь **1-9-р баганын** мэдээллийг сар бүрийн 5-ны дотор онлайн программд шивж, цаасаар баталгаажуулж харьяа аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

Ажил олгогч нь **тодруулсан 10-р баганын** мэдээллийг улирлын дараа сарын 5-ны дотор онлайн программд шивж, цаасаар баталгаажуулж харьяа аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

Ажил олгогч нь **тодруулсан 11, 12-р баганын** мэдээллийг жил бүрийн 2-р сарын 5-ны дотор, хэрэв өөрчлөлт орсон тохиолдолд улирлын дараа сарын 5-ны дотор онлайн программд шивэх ба цаасаар баталгаажуулж аймаг, дүүрэг/сум/-ийн нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

Ажил олгогч гэж эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод дараах төрлийн хөлс, орлого хамаарна. Үүнд:

- ~ Цалин хөлс(үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал),
- ~ Сул зогсолтын үеийн олговор,
- ~ Ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд түр шилжүүлэх үеийн цалин хөлс,
- ~ Ажил хүлээлцэх хугацааны олговор,
- ~ Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтанд олгох тэтгэмж, олговор,
- ~ Хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй олговор,
- ~ Үндэслэлгүй халсан буюу шилжүүлсэн үеийн олговор,
- ~ Ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөлс,
- ~ Сайн дураар даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлого,
- ~ Аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого.

1-4-р баганад даатгуулагчийн эцэг/ эхийн нэр, нэр, регистрийн дугаар, нийгмийн даатгалын дэвтрийн дугаарыг бичнэ.

5-р баганад даатгуулагчийн төрлийн 2 оронтой кодыг бичих ба тухайн даатгуулагч нь ямар төрөлд хамаарахаас шалтгаалж код нь өөр өөр байна.

6-р баганад даатгуулагчдын тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг төгрөгөөр бүртгэж бичих ба нийт дүн нь НД-7 маягтын 8-р мөрийн 6-р баганад бичигдсэн тоотой тэнцүү байна.

7-р баганад даатгуулагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан шимтгэлийн дүнг төгрөгөөр бичнэ.

8-р баганад даатгуулагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан шимтгэлийн ажил олгогчоос гарч буй зардлыг бичнэ.

9-р баганад даатгуулагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан шимтгэлийн даатгуулагч өөрөөс нь гарч буй зардлыг бичнэ.

10-р баганад даатгуулагчийн ажил, мэргэжлийн ангиллын кодыг 3 оронгийн түвшинд нөхөж бичих бөгөөд уг гарын авлагын 16-38-р хуудсанд буй Үндэсний Ажил, мэргэжлийн ангилал - 08-аас харж, аль ангилалд хамаарахыг тодорхойлж, тохирох кодыг нөхөж бичнэ. Ажил олгогч нь эхний улирал буюу 2014 оны 1-р улиралд бүх даатгуулагчдыг ажил, мэргэжлийн ангиллын 3 оронгийн түвшинд кодолно. Харин дараагийн улирлуудад өөрчлөлт орсон даатгуулагчийн ажил, мэргэжлийн ангиллын кодыг мэдээлж байна.

11-р баганад даатгуулагчтай харилцах утасны дугаарыг бичих бөгөөд нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэхэд ашиглана. Энэ мэдээллийг жилд 1 удаа мэдээлэх ба хэрэв өөрчлөлт орсон тохиолдолд маягтын баруун дээд талд буй мэдээллийн урсгалд заасан хугацаанд багтаан цахим болон цаасан хэлбэрээр нийгмийн даатгалын байгууллагад мэдээлж байна.

12-р баганад даатгуулагчийн и-мэйл хаягийг бичих бөгөөд нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэхэд ашиглана. Энэ мэдээллийг жилд 1 удаа мэдээлэх ба хэрэв өөрчлөлт орсон тохиолдолд маягтын баруун дээд талд буй мэдээллийн урсгалд заасан хугацаанд багтаан цахим болон цаасан хэлбэрээр нийгмийн даатгалын байгууллагад мэдээлж байна.

Маягт НД-8 дээр бичигдсэн даатгуулагч тус бүрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэл нь даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн дүнтэй тохирч байх бөгөөд гагцхүү энэ тохиолдолд нийгмийн даатгалын байцаагч тухайн даатгуулагчийн дэвтэрт гарын үсэг зурж тэмдэг дарна.

Ажил олгогчийн дарга /захирал/, нягтлан бодогч нь даатгуулагчийн нийгмийн даатгуулагчийн шимтгэл ногдуулалт, төлөлтийн хуудсанд гарын үсэг зурж тамга тэмдэг дарсан байх бөгөөд нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/ шалгаж хүлээн авч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

Ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн хуудсыг хоёр хувь үйлдэх бөгөөд нэгийг нь тухайн ажил олгогчид, нөгөөг нь харьцаж буй нийгмийн даатгалын байгууллагад хадгална.

Даатгуулагчийн төрлийн код

Даатгуулагчийн төрөл		Шимтгэл төлөх хувь хэмжээ										Бүгд	
Код	Нэр	Шимтгэл тооцох ЦХХТАО	Тэтгэвэр		Тэтгэмж		ЭМД		Ажилгүйдэл		Үйлдвэрлэлийн осол		
			Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч		Даат-гуулагч
01	Энгийн ажилтан	цалин	7	7	0.8	0.8	2	2	0.2	0.2	1-3		21-23
11	Цэрэг цагдаагийн ажилтан	цалин					2	2					4
14	Сул зогсогч олговортой	Олговор	7	7	0.8	0.8	2	2	0.2	0.2	1-3		21-23
33	Сул зогсогч олговоргүй	Доод хэм	7		0.8		2		0.2		1-3		11-13
20	Ажил олгогчийн захиалгаар суралцагч	Доод хэм	7		0.8								7.8
06	Хүүхдээ асарч буй эх	Доод хэм	7		0.8								7.8
17	Жирэмсэн амаржсаны чөлөөлт эх	Доод хэм	7		0.8		2		0.2		1-3		11-13
21	1 сараас дээш хугацаагаар ХЧАлдсан даатгуулагч	Доод хэм	7		0.8		2		0.2		1-3		11-13
22	Тэтгэвэр тогтоолгосон ажиллагч	цалин	7	7	0.8	0.8					1-3		16.6-18.6
23	Гадаадын иргэн Сертификатгүй	цалин	7	7	0.8	0.8	2	2	0.2	0.2	1-3		21-23
24	Гадаадын иргэн Сертификаттай /Солонгос/	цалин			0.8	0.8	2	2	0.2	0.2	1-3		7-9
19	Онцгой нөхцлөөр /Тусгай гэрээгээр/ 11-13 хувь төлөгч	цалин	7		0.8		2		0.2		1-3		11-13
25	7 сараас дээш улирлын чанартай байгууллагад ХГ-ээр ажиллагч /ажил зогссон үед/	Доод хэм	7		0.8		2		0.2		1-3		11-13
26	Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж буй МУ-ын иргэн /солонгос/	Журам	7										7
28	Улсын хил дээр алба хааж буй гаалийн улсын байцаагчийн гэр бүл	Доод хэм	7				2						9
29	Улсын хил дээр алба хааж буй офицер, ахлагчийн гэр бүл	Доод хэм	7		0.8		2		0.2		1-3		11-13
30	Дипломат төлөөлөгчийн газар ажиллагчийн гэр бүл	дундаж	7		0.8		2		0.2		1-3		11-13
31	Ажиллаагүй үедээ дайчлагдсан даатгуулагч	Доод хэм	7		0.8								7.8
32	Хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хоригдсон	дундаж	7		0.8								7.8
08	Хугацаат цэргийн албан хаагч	Доод хэм	7		0.8		төр хар						7.8
34	Тэтгэвэр тогтоолгосон ажиллагч сул зогссон	Доод хэм	7		0.8						1-3		8.8-10.8
35	Цэрэг цагдаагийн ажилтан сул зогссон	Доод хэм					2						2
37	Лам санваартан /хуулийн 4.2.1-ээс бусад/	Доод хэм	7	7	0.8	0.8							15.6
38	Тэтгэвэр тогтоолгосон ажиллагч /ЖА чөлөөтэй/	Доод хэм	7		0.8						1-3		8.8-10.8
39	Тэтгэвэр тогтоолгосон ажиллагч /1 сараас дээш ХЧАлдсан/	Доод хэм	7		0.8						1-3		8.8-10.8
40	Үндсэн ажлаас гадуур ажил гүйцэтгэгч /15А дэвтэртэй/	цалин	7	7	0.8	0.8	2	2	0.2	0.2	1-3		21-23

ҮАМАТ – 08
ISCO - 08

ҮНДЭСНИЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА
ТОДОРХОЙЛОЛТЫГ АШИГЛАХ ЗААВАР



НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Үндэсний ажил мэргэжил, албан
тушаалын жагсаалт, ангилал,
тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08 (YAMAT-08)-ыг 1, 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.
2. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтын дагуу өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдөхийг зөвлөсүгэй.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт батлах тухай" 1998 оны А/315 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.ГАНДИ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Олон Улсын ажил, мэргэжлийн стандарт ангилал-08 (ISCO-08)-ын үзэл баримтлал, суурь зарчимд дүйцүүлэн боловсруулсан, манай улсын “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд/хуучнаар/-ын 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаалаар батлан мөрдүүлж байна.

“YAMAT-08”-ын үндсэн зорилго нь орчин үеийн технологийн хувьслын агуулга, процесст дүйсэн нэр, агуулгаар ажил, мэргэжлийг ангилах, хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хамгааллын холбогдолтой мэдээлэл цуглуулах, боловсруулах, шийдвэр гаргах үе шат бүхэнд мэдээллийн бодит чанарыг хангах, олон улсын хэмжээнд судалж, харьцуулах боломжийг дээшлүүлэх явдал юм.

Энэ ангиллын **үзэл баримтлалын тухайд**, олон улсын болоод үндэсний ангилал, тодорхойлолтод “ажил ба мэргэжил” гэсэн 2 чухал ухагдахууныг үндэс болгосон.

“Ажил” гэж энэхүү ангиллын статистик нэгж болох нэг ажлын байр буюу нэг хүний хийж гүйцэтгэх **зорилт даалгавар, үүрэг хариуцлагын нэгдэл**. Нэгж буюу нэг хүн гэдэгт ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч аль аль нь орно. Ажил (ажлын байр) гэдэгт албан тушаалыг хамруулан ойлгоно.

“Мэргэшил” гэж тухайн төрлийн үйл ажиллагааны хүрээнд тодорхой даалгавар, хариуцлагыг биелүүлэх ажилтны чадвар.

Үндсэн зорилт, даалгавар, үүрэг хариуцлага нь дээр зэргээр адилсах шинж чанар, агуулгатай болсон ажлын багц нь ажил мэргэжил (occupation) юм.

“YAMAT-08”-д аливаа ажилтны албан боловсрол, сургалтын түвшинд бус, харин тодорхой даалгавар, хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах мэргэшил-чадварт илүү түшиглэсэн болно.

“YAMAT-08”-ын үндсэн, дэд, бага, нэгж бүлгийг мэргэшлийн зохих түвшнээр доорх хүснэгтэд харууллаа. Энд ажил, мэргэжлийн ангиллын үндсэн бүлэгт хамаарах хүнд харьяалагдах кодыг тухайн хүний эзэмшсэн мэргэжилтэй нь дүйцүүлэн харгалзах кодыг олоход хялбаршуулсан байдлыг тусгахыг хичээлээ. Гэхдээ ямар ч ажил, мэргэжлийг ямар ч түвшний боловсролтой хүн хийдэг байж болох талтай юм.

Үндсэн бүлэг	Дэд бүлэг	Бага бүлэг	Нэгж бүлэг	Мэргэшлийн түвшин
1. Менежер	4	11	31	Их, дээд сургууль болон түүний дараах шатны боловсрол, түүнтэй адилтгах түвшин шаардагдах ажил, мэргэжил
2. Мэргэжилтэн	6	27	92	
3. Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	5	20	84	
4. Контор, үйлчилгээний ажилтан	4	30	29	Мэргэжлийн дунд шатны боловсрол шаардах ажил, мэргэжил
5. Худалдаа, үйлчилгээний ажилтан	4	13	40	
6. Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	3	9	18	
7. Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	5	14	52	
8. Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	3	14	54	
9. Энгийн ажил, мэргэжил	6	12	20	Бага болон бүрэн бус дунд боловсролтой буюу мэргэжлийн анхан шатны боловсрол үл шаардах энгийн ажил, мэргэжил
0. Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	3	3	1	Зэвсэгт хүчний зэрэглэлийн ажил, мэргэжил
Дүн	43	153	421	-
Мэргэжлийн тоо	-	-	3978	-

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Ажил, мэргэжлийн оноосон нэр, индекс/кодыг хайхад баримтлах зарчим:

“ҮАМАТ-08”-аас хэрэгцээтэй ажил, мэргэжлийн нэр, индекс/кодыг олохын тулд бүлгийн дарааллаар хайна. Үүнд:

- Үндсэн бүлэг – 2 “Мэргэжилтэн”
- Дэд бүлэг – 23 “Багшлах мэргэжилтэн”
- Бага бүлэг – 231 “Их, дээд сургуулийн дээд боловсрол олгох багш”

ҮНДСЭН БҮЛЭГ 1 – МЕНЕЖЕР

Тодорхойлолт: Менежер нь засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдаж чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавина.

Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллагын зохион байгуулалтын нэгжийн бодлого, төсөв, журмыг боловсруулах, зөвлөгөө өгөх, зорилт тодорхойлж, стандарт тогтоох, бодлого, хөтөлбөрийг журмыг боловсруулах, үнэлэх, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд тохирох тогтолцоо, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх, бодлого, хөтөлбөрийг хэрэгцүүлэхийн тулд эд материалын, хүн хүчний болон санхүүгийн нөөцийг зарцуулах зөвшөөрөл олгох, байгууллага, аж ахуйн нэгж, түүний ажилтны ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, ажилтныг сонгох буюу сонгосон ажилтныг ажилд томилох, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хурал цуглаан бусад чуулга уулзалтанд засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага буюу түүний зохион байгуулалтын нэгжийг төлөөлөх, тэдгээрийн өмнөөс хэлэлцээ хийх.

- 11 Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал
 - 111 Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан
 - 112 Захирал, гүйцэтгэх захирал
- 12 Захиргаа, арилжааны менежер
 - 121 Бизнес, үйлчилгээ, захиргааны менежер
- 13 Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер
 - 131 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын үйлдвэрлэлийн менежер
 - 132 Үйлдвэр, уурхай, барилга угсралт, хангамж түгээлтийн менежер
 - 133 Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер
 - 134 Мэргэшсэн үйлчилгээний менежер
- 14 Зочид буудал, худалдаа, холбогдох бусад үйлчилгээний менежер
 - 141 Зочид буудал, рестораны менежер
 - 142 Жижиглэн болон бөөний худалдааны менежер
 - 143 Холбогдох бусад үйлчилгээний менежер

ҮНДСЭН БҮЛЭГ 1 - т холбогдох ажил, мэргэжлийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээс харна уу.

ҮНДСЭН БҮЛЭГ 1 - МЕНЕЖЕР			
Дэд бүлэг	Дэд бүлгийн нэршил	Бага бүлэг	Холбогдох ажил, мэргэжил
11	Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал	111	Хууль тогтоогч, засаг дарга, олон нийтийн болон Төрийн бус байгууллагын удирдах ажилтан
		112	Захирал, гүйцэтгэх захирал, дэд захирал, дэд болон орлогч дарга
12	Захиргаа, арилжааны менежер	121	Санхүү, хүний нөөц, бодлого төлөвлөлт, бизнес үйлчилгээ, захиргаа, маркетинг, борлуулалт, зар сурталчилгаа, олон нийттэй харилцах, судалгаа, хөгжлийн менежер
13	Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер	131	ХАА, ой, загас агнуур, усны амьтан үржүүлэгч, загасны АА-н үйлдвэрлэлийн менежер
		132	Үйлдвэр, уурхай, барилга угсралт, хангамж түгээлт, холбогдох менежер
		133	Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер
		134	Эрүүл мэнд, хүүхэд болон өндөр настан асрамжлах үйлчилгээ, нийгмийн халамж, боловсрол, банк, санхүү, даатгал, бусад мэргэшсэн үйлчилгээний менежер
14	Зочид буудал, худалдаа, холбогдох бусад үйлчилгээний	141	Зочид буудал, рестораны менежер
		142	Жижиглэн болон бөөний худалдааны менежер
		143	Соёл, спорт, амралтын төв болон бусад холбогдох үйлчилгээний төвийн менежер

ҮНДСЭН БҮЛЭГ 2 – МЭРГЭЖИЛТЭН

Тодорхойлолт: Энэхүү ангиллын мэргэжлийн ажилтан нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан юм уу урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, эдгээрийг системчилсэн хэлбэрээр заан сургах буюу тус үйл ажиллагааны аливаа хослолыг мэргэшлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг.

Шинжилгээ, судалгаа хийх, үзэл баримтлал, онол, үйлдлийн арга барилыг боловсруулж, хөгжүүлэх, математик, инженерчлэл, технологи зэрэг амьгүй байгалийн, анагаах, эрүүл мэндийн үйлчилгээ, тэрчлэн нийгэм ба хүмүүнлэгийн зэрэг амьд байгалийн ухааны мэдлэгийг хэрэглэх юмуу түүгээр зөвлөгөө өгөх, боловсролын төрөл бүрийн төвшинд нэг юм уу түүнээс дээш тооны хичээлээр онол, практик зааж багшлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сурган боловсруулах, төрөл бүрийн бизнес, хууль зүй, социал үйлчилгээ хийх, урлагын бүтээл туурвих, оюун санааны удирдамж өгөх, шинжилгээ судалгааны илтгэл, тайлан баримт бичиг бэлтгэх. Бусад ажилтныг удирдах үүрэг орж болно.

ҮНДСЭН БҮЛЭГ 2 - МЭРГЭЖИЛТЭН

- 21 Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн
 - 211 Биет бодис/физик/, гео судлалын мэргэжилтэн
 - 212 Математикч, актуарч, статистикч
 - 213 Амьд байгалийн ухааны мэргэжилтэн
 - 214 Инженер мэргэжилтэн (цахим-технологийн бусад)
 - 215 Цахилгаан, цахим-технологийн инженер
 - 216 Архитекторч, төлөвлөгч, зурагзүйч, байрзүйч, дизайнер
- 22 Эрүүл мэндийн мэргэжилтэн
 - 221 Хүний их эмч
 - 222 Сувилахуй, эх барихуйн мэргэжилтэн
 - 223 Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн
 - 224 Яаралтай тусламжийн эмч, ажилтан
 - 225 Малын эмч
 - 226 Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн
- 23 Багшлах мэргэжилтэн
 - 231 Их, дээд сургуулийн дээд боловсролын багш
 - 232 Техник мэргэжлийн боловсролын багш
 - 233 Дунд боловсролын багш
 - 234 Анхан шатны болон сургуулийн өмнөх боловсролын багш, сурган хүмүүжүүлэгч
 - 235 Бусад багшлах мэргэжилтэн
- 24 Бизнес, захиргааны мэргэжилтэн
 - 241 Санхүүгийн мэргэжилтэн
 - 242 Захиргааны мэргэжилтэн
 - 243 Борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн
- 25 Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн
 - 251 Програм хангамж, хэрэглээний програм зохиогч, шинжээч
 - 252 Өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн
- 26 Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн
 - 261 Эрх зүйн мэргэжилтэн
 - 262 Номын санч, архивч, музейн харгалзагч
 - 263 Нийгэм, соёл, шашны мэргэжилтэн
 - 264 Зохиолч, сэтгүүлч, хэл шинжээч
 - 265 Уран бүтээлч, жүжигчин

ҮНДСЭН БҮЛЭГ 2 - т холбогдох ажил, мэргэжлийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээс харна уу.

ҮНДСЭН БҮЛЭГ 2 - МЭРГЭЖИЛТЭН			
Дэд бүлэг	Дэд бүлгийн нэршил	Бага бүлэг	Холбогдох ажил, мэргэжил
21	Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн	211	Физикч, одон орон судлаач, цаг уурч, химич, геологич, геофизикч
		212	Математикч, актуарч, статистикч
		213	Биологич, ботаникч, амьтан судлаач, фермч, ойн болон загасны аж ахуйн зөвлөгч, байгаль хамгааллын мэргэжилтэн
		214	Аж үйлдвэр, иргэний барилга, байгаль орчин, механикч, хими, уул уурхай, металлургич болон бусад холбогдох бусад инженер
		215	Цахилгаан, цахим зүй болон телехолбооны инженер
22	Эрүүл мэндийн мэргэжилтэн	216	Барилгын болон газар тохижуулалтын архитекторч, хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч, зурагзүйч, байрзүйч болон хувцас, бүтээгдэхүүн, график, мультимедиа зохиомжийн дизайнер
		221	Ерөнхий мэргэжлийн болон нарийн(төрөлжсөн) мэргэжлийн их эмч
		222	Сувилахуйн болон эх барихуйн мэргэжилтэн
		223	Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн
		224	Яаралтай тусламжийн эмч
		225	Малын эмч
23	Багшлах мэргэжилтэн	226	Нүүр ам, шүд, нөхөн сэргээх эмчилгээний эмч, эрүүл ахуй, ариун цэвэр, хоол тэжээл болон сонсголын мэргэжилтэн, хэлний согог засалч, хоолны арга зүйч, хараа зүйч, хараа хэмжигч болон эрүүл мэндийн бусад мэргэжилтэн
		231	Дээд боловсрол олгох багш
		232	Техник мэргэжлийн боловсролын багш
		233	Дунд боловсрол олгох багш
		234	Анхан шатны болон сургуулийн өмнөх боловсрол олгох багш, сурган хүмүүжүүлэгч
24	Бизнес, захиргааны мэргэжилтэн	235	Боловсролын арга зүйч, тусгай хэрэгцээт боловсрол, өөр хэл, дуу хөгжим, соёл урлаг, мэдээллийн технологийн болон багшлах бусад мэргэжилтэн
		241	Нягтлан бодогч, санхүү хөрөнгө оруулалтын зөвлөх, санхүүгийн мэргэжилтэн, шинжээч
		242	Байгууллагын удирдлага, задлан шинжээч, захиргаа, хүний нөөц, мэргэжлийн зөвлөгөө өгөгч, сургалтын болон боловсон хүчнийг хөгжүүлэх албаны мэргэжилтэн
25	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн	243	Зар сурталчилгаа, борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах алба, техник, мэдээлэл, холбооны технологи болон эмнэлгийн борлуулалтын мэргэжилтэн
		251	Програм болон вэб мультимедиа, хэрэглээний програм, зохиогч, мэдээллийн системийн шинжээч
		252	Системийн эрхлэгч, өгөгдлийн сангийн дизайнер, эрхлэгч, компьютерийн сүлжээ болон бусад өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн
26	Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн	261	Эрх зүйч, хуульч, шүүгч, эрх зүйн бусад мэргэжилтэн
		262	Архивч, музей харгалзагч, номын санч, холбогдох бусад мэргэжилтэн
		263	Эдийн засагч, социологич, хүн судлаач, соёл судлаач, философич, улс төр судлаач, түүхч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, шашны мэргэжилтэн, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн
		264	Зохиолч, сэтгүүлч, хэл шинжээч, орчуулагч, хэлмэрч нийтлэлч, бусад шинжээч
		265	Дүрслэх урлаач, хөгжмийн зохиолч, хөгжимчин, дуучин, бүжиг дэглэгч, бүжигчин, кино тайзны найруулагч, жүжигчин, радио, телевиз, бусад мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэгч, бусад уран бүтээлч

ҮНДСЭН БҮЛЭГ 3 – ТЕХНИКЧ БОЛОН ТУСЛАХ/ДЭД МЭРГЭЖИЛТЭН

Тодорхойлолт: Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн нь гол төлөв судалгаа шинжилгээ, болон хавсрага ухаан, урлаг, үйл ажиллагааны баримтлал, арга техник ашиглах, төр, бизнесийн дүрэм журамтай холбоотой техникийн нь шинжтэй ажил хийж гүйцэтгэнэ.

Инженер, технологи зэрэг биет бодисын ухаан, эрүүл мэнд, нийгэм, хүмүүнлэгийн зэрэг амьд байглийн ухааны салбарт онол, үзэл баримтлал, агуулахыг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийтэй холбоотой техник ажил хийж гүйцэтгэх, худалдаа, санхүү, нийгмийн ажил болон төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зэрэг захиргааны ажилтай холбоотой төрөл бүрийн техникийн үйлчилгээ, ажил гүйцэтгэх уран сайхан, зугаа цэнгүүнтэй холбоотой ажил гүйцэтгэх, спортын арга хэмжээнд хамрагдах, шашны зарим нэг үйл хийх.

ҮНДСЭН БҮЛЭГ 3 – ТЕХНИКЧ БОЛОН ТУСЛАХ/ДЭД МЭРГЭЖИЛТЭН

- 31 Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн
 - 311 Инженерийн ухааны техникч
 - 312 Уурхай, үйлдвэр, барилга угсралтын байцаагч
 - 313 Технологи процесс, чанар шалгагч техникч
 - 314 Амьд байгалийн ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн
 - 315 Усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч
- 32 Эрүү мэндийн туслах/дэд мэргэжилтэн
 - 321 Анагаахын болон эм зүйн техникч
 - 322 Сувилахуйн болон эх барихуйн туслах/дэд мэргэжилтэн
 - 323 Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд мэргэжилтэн
 - 324 Мал эмнэлгийн техникч, туслах ажилтан
 - 325 Эрүүл мэндийн бусад туслах/дэд мэргэжилтэн
- 33 Бизнесийн болон захиргааны туслах/дэд мэргэжилтэн
 - 331 Санхүү, математик тооцооллын туслах/дэд мэргэжилтэн
 - 332 Борлуулалт, худалдан авалтын агент, брокер
 - 333 Бизнес үйлчилгээний агент
 - 334 Захиргааны төрлийн мэргэжлийн нарийн бичгийн дарга
 - 335 Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн ажилтан
- 34 Хууль, нийгэм, соёл, тэдгээрт холбогдох туслах/дэд мэргэжилтэн
